

Захиргааны хэм хэмжэний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 06. сарын 14..-ны
өдрийн 530.4 дугаарт бүртгэв.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

“Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийн журам”-ыг шинэчлэн
батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 38 дугаар тогтоол, 2015 оны 40 дүгээр тогтоол, 2016 оны 26 дугаар тогтоол болон 2020 оны 82 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн
34 тоот тогтоолын
хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болгох, шилжүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай болон бусад холбогдох хуулиар тус тус эрх олгогдоно дагуу харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зохицуулалт¹-ын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, үр ашигтай зохион байгуулах ба харилцаа холбооны сүлжээ үйлчилгээний зохицуулалтын олон улсын чиг хандлагад нийцүүлэн, зах зээлд шударга өрсeldхөн нөхцөлийг бүрдүүлэх, ижил тэгш үйлчлэх, ил тод, бие даасан байх зарчмыг баримтална.
- 1.3. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гэдэгт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухайн хуулийн 15.16.1-15.16.3, 15.16.5-15.16.7-д заасан тусгай зөвшөөрөл тус тус хамаарна.
- 1.4. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл болон эрхлэх үйлчилгээг тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээнд зааж өгнө.
- 1.5. Зохицуулах хороо нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Харилцаа холбооны салбарт төрөөс баримтлах бодлогыг баримтлан тусгай зөвшөөрлийг хуульд нийцүүлэн сонгон шалгаруулалтаар олгож болох ба сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэхүү журмаас тусад нь баталж мөрдөнө.
- 1.6. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоож² тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээд уг нөхцөл шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж³ ажиллана.
- 1.7. Зохицуулах хороо нь энэхүү журамд заасан тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх ба холбогдох аргачлал, мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулна.

¹ Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.15.“зохицуулалт” гэж мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шилжүүлэх болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоохтой холбоотой журам батлах, гэрээ байгуулах, хяналт тавих, хууль тогтоомжид заасан асуудлаар шийдвэр гаргахтай холбогдсон цогц үйл ажиллагааг;

² Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2, 9.1.3

³ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3

1.8. Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 14.2, Радио долгионы тухай хуулийн 11.2.2, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10.2 болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр эсхүл хүсэлт гаргагч этгээдийн ирүүлсэн хүсэлт нь энэ журамд заасан нөхцөл, шаардлагын аль нэгийг хангахгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах ба татгалзсан тухай үндэслэлийг тодорхой дурдсан хариуг тусгай зөвшөөрөл хүсэгчид бичгээр хүргүүлнэ.

**ХОЁР. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ НӨХЦӨЛ, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

2.1. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

2.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичиг болон эрхлэх үйлчилгээнээс хамааруулан Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан, энэхүү журмын хавсралт 1-ээс 4-т дурдсан мэдээллийг ирүүлнэ.

2.3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл хүсэгчээс болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл хүсэгчийн талаар тодруулга мэдээлэл авч болно.

**ГУРАВ. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

3.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг бүрэн, үнэн зөв бүрдүүлж, хуудас бүрийг дугаарлан Зохицуулах хороонд хүргүүлнэ.

3.2. Зохицуулах хорооны ажлын алба нь энэ журмын 3.1-д заасан баримт бичгийн иж бүрдлийг шалгах, бүртгэл хөтлөх, хүлээн авах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх бөгөөд баримт бичиг дутуу иж бүрдлийг, баримт бичиг бүрдүүлэхтэй холбоотой зааварчилгааны хамт хүсэлт гаргагчид буцаан хүргүүлнэ.

3.3. Зохицуулах хороо нь энэхүү журмын 3.2-т заасны дагуу хүлээж авсан баримт бичгийн иж бүрдэлд үндэслэн ирүүлсэн хүсэлт нь холбогдох хууль, тогтоомж, энэхүү журмын Хавсралт 1-ээс 5-д заасан шаардлага хангасан эсэхэд өөрийн ажлын албадаар дамжуулан үнэлгээ хийнэ.⁴

3.4. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангахгүй буюу тодруулга шаардлагатай тохиолдолд холбогдох баримт бичгийг нэмэлтээр ирүүлэхийг зөвшөөрөл хүсэгчид цахим шуудан болон утсаар мэдэгдэж, тэмдэглэл үйлдэх ба хүсэлт гаргагч нь мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор нэмэлт материал ирүүлнэ. Хэрэв

⁴ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.1-ыг үндэслэн

дурдсан хугацаанд нэмэлт материал ирүүлээгүй тохиолдолд шаардлага хангаагүй гэж үзнэ.

3.5. Зохицуулах хорооны ажлын албад нь энэхүү журмын 3.3-т заасны дагуу үнэлгээ хийж шаардлага хангасан гэж дүгнэсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх ба уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор багтаан тусгай зөвшөөрөл хүсэгчид бичгээр мэдэгдэнэ.

3.6. Зохицуулах хорооны ажлын албад шаардлага хангаагүй гэж дүгнэсэн, эсхүл Зохицуулах хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзсан тохиолдолд татгалзсан талаарх үндэслэл, тайлбарыг ирүүлсэн иж бүрдлийн хамт хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.7. Зохицуулах хороо нь ирүүлсэн хүсэлтийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.4⁵-т заасан нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд уг хуулийн 12.1-д заасны дагуу ажлын 21 хоног, Радио долгионы тухай хуулийн 11.2-т заасны дагуу ажлын 30 хоногт шийдвэрлэх ба зөвшөөрөл хүсэгч нь тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг авах эрхтэй.

3.8. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг холбогдох журам, сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу зохион байгуулж, хорооны хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СҮНГАХ

4.1. Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1, 6.2, Харилцаа холбооны тухай хуулийн 12.2, Радио долгионы тухай хуулийн 12.1, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн энэхүү журмын Хавсралт 1,2,3,4-т зааснаас багагүй хугацаагаар сунгана.

4.2. Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тухайн Радио равтамж, радио давтамжийн зурvas ашиглах тусгай зөвшөөрлийн хугацааг энэхүү журмын Хавсралт 2-т зааснаас өөр хугацаагаар сунгаж болно.

4.3. Хуульд тусгайлан заагаагүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтээ тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60-аас багагүй хоногийн өмнө дараах мэдээллийн хамт Зохицуулах хороонд ирүүлнэ. Үүнд:

- 4.3.1. Албан хүсэлт;
- 4.3.2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний үүргийг хэрхэн биелүүлж ажилласан тухай тайлан, мэдээлэл;
- 4.3.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;
- 4.3.4. Тусгай зөвшөөрлийн гэрээ;
- 4.3.5. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд шинэчилсэн мэдээлэл;

⁵ 12.4. Магадлан шинжилгээ хийлгэх тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

4.4. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хуулиар тусгайллан заасан бол тухайн хуульд заасан хугацаанд, бусад тохиолдолд хүсэлтийг хүлээж авснаас хойш ажлын 21 хоногт багтаан хянаж, хорооны даргын тушаалаар шийдвэрлэнэ.

4.5. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага биелүүлж ажилласан байдлыг үндэслэх ба шаардлагатай тохиолдолд нэмэлт мониторинг, шалгалт хийж болно.

4.6. Зохицуулах хороо нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.4-өөс гадна дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахгүй бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах боломжгүй тохиолдолд үндэслэлийг тодорхой дурдсан албан бичгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ. Үүнд:

- 4.6.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн;
- 4.6.2. Тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;
- 4.6.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлт хангалтгүй;
- 4.6.4. Хууль, журамд заасан бусад үндэслэл

4.7. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах ба гэрээний үүргийн хэрэгжилт, нөхцөл, шаардлагын биелэлт дүгнэх аргачлалыг Зохицуулах хорооны даргын тушаалаар баталж, мөрдөнө.

ТАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

5.1. Дараах тохиолдолд тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба нэмэлт, өөрчлөлтийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтэд үндэслэн Зохицуулах хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ. Үүнд:

- 5.1.1. Үйлчилгээний хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 5.1.2. Эрхлэх үйлчилгээний төрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 5.1.3. Радио давтамж, радио давтамжийн зурваст нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 5.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр (Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн) өөрчлөх.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 5.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг энэхүү журмын Хавсралт 5-д заасан баримт бичгийг хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

5.3. Энэ журмын 5.2-т заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг Зохицуулах хорооны ажлын албад энэ журмын хавсралт 5-д заасан шаардлага хангасан гэж үнэлсэн тохиолдолд энэхүү журмын 5.1.1-5.1.3-т заасан асуудлыг Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх бөгөөд 5.1.4-т заасан асуудлыг тусгай зөвшөөрөл, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэнэ.

5.4. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг 30 хоногийн дотор багтаан шийдвэрлэж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

5.5. Зохицуулах хороо нь энэхүү журмын Хавсралт 5-д заасан шаардлагын аль нэг нь хангагдаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулахаас татгалзах ба татгалзсан үндэслэлийг тодорхой дурдсан хариуг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

5.6. Тусгай зөвшөөрлийг зөвхөн хуульд заасан тохиолдолд шилжүүлнэ.

5.7. Тусгай зөвшөөрлийг энэхүү журмын 5.6-д заасны дагуу шилжүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлэх ба Зохицуулах хороо нь холбогдож хууль, тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ. Үүнд:

5.7.1. Тусгай зөвшөөрөл шилжүүлэх шалтгаан, нөхцөл байдлыг тодорхой тусгасан 2 талын хүсэлт;

5.7.2. Тусгай зөвшөөрөл шилжүүлэх болон шилжүүлж авах этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар.

ЗУРГАА. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ

6.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14.1, холбогдох бусад хууль тогтоомжид зааснаас гадна тусгай зөвшөөрлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар, Зохицуулах хорооны шийдвэрээр түдгэлзүүлнэ.

6.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх нөхцөл бүрдсэн тохиолдолд энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн дагуу зохион байгуулна.

6.3. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай мэдэгдлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтын дагуу 3 хоногт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяа Татварын албанд албан бичгээр мэдэгдэнэ.

6.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түдгэлзүүлсэн хугацаанд шинээр хэрэглэгч бүртгэхгүй, үйл ажиллагаагаа өргөжүүлэхгүй байна.

6.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө бүрэн арилгах бөгөөд зөрчлөө арилгасан тухай тайлан, нотлох баримтыг Зохицуулах хороонд ирүүлнэ. Зохицуулах хороо нь ирүүлсэн тайлан, нотлох баримттай танилцаж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь холбогдох шалгалтыг хийж, дүгнэлт гаргаж болно.

6.6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл бүрэн арилсан тохиолдолд тухайн тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд зөрчлөө бүрэн арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ДОЛОО. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ДУУСГАВАР БОЛСОНД ТООЦОХ

- 7.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1, Харилцаа холбооны тухай хуулийн 15.1, Радио долгионы тухай хуулийн 18.1, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан нөхцөл үүссэн тохиолдолд Зохицуулах хорооны шийдвэрээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 7.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл бүрдсэн тохиолдолд энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн дагуу зохион байгуулна.
- 7.3. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.2-д заасны дагуу ажлын 3 хоногт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч, харьяа Татварын алба, шаардлагатай бол бусад холбогдох үйлчилгээ эрхлэгчдэд албан бичгээр хүргүүлнэ.
- 7.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдолд түүнд хамаарах радио давтамж, давтамжийн зурvas ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хамтад нь шийдвэрлэнэ.
- 7.5. Харилцаа холбооны тухай хуулийн 15.1.3-ыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор хэрэглэгчдэд үйлчилгээ авах боломжийг бүрдүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 7.6. Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Радио долгионы тухай хуулийн 17 дугаар зүйл, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17 дугаар зүйл болон холбогдох бусад хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл дуусгавар болох бөгөөд түүнээс үүдэн гарах хохиролыг Зохицуулах хороо хариуцахгүй.

НАЙМ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

- 8.1. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарсан тохиолдолд Зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах ба дараах дараалал, зарчмыг баримтална. Үүнд:

- 8.1.1. Зохицуулах хорооны ажлын алба нь гэрээний тесэл, тухайн тусгай зөвшөөрөлтэй холбоотой зөвлөмж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийн нэхэмжлэх зэргийг тусгай зөвшөөрөл хүсэгчид тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор цахим шуудангаар хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
- 8.1.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь гэрээний төслийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан Зохицуулах

хороонд шуудангаар эсхүл биеэр ирүүлэх бөгөөд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлсөн байна.

8.1.3. Иргэн тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулж байгаа тохиолдолд гэрээнд гарын үсэг зурж, "Гарын үсгийн баталгаа"-г нотариатаар баталгаажуулан гэрээнд хавсаргаж ирүүлнэ.

8.1.4. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь эхний жилийн төлбөрөө бүрэн төлсөн, тусгай зөвшөөрлийн гэрээг баталгаажуулж ирүүлсэн тохиолдолд тухайн гэрээг ирүүлснээс хойш 5 хоногийн дотор Зохицуулах хорооны даргаар баталгаажуулан зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээг тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох ба тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээг хүлээлгэж өгсөн тухай тэмдэглэл үйлдэнэ.

8.2. Хүсэлт гаргагч нь 8.1.2-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн гэрээг баталгаажуулж ирүүлээгүй эсхүл эхний жилийн төлбөрөө бүрэн төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээг баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгохгүй бөгөөд тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүчингүй болгоно.

8.3. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан, нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн гэрээг шинэчлэн байгуулах бөгөөд ингэхдээ энэхүү журмын 8.1-д заасан дараалал, шаардлагыг баримтална.

8.4. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдлыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, эрхлэх үйлчилгээний төрлөөс хамааруулан 1-ээс 2 жил тутам дүгнэх ба тухай бүр тусгай зөвшөөрөл эзэмшигч болон олон нийтэд мэдээлж ажиллана.

8.5. Холбогдох хууль тогтоомж болон энэхүү журамд зааснаас бусад тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулах бөгөөд эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн гэрээнд нэмэлт нөхцөл, үүргийг тусгаж болно. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн гэрээнд нэмэлт, нөхцөл, үүргийг тусгахдаа үл ялгavarлах зарчмыг баримтлана.

8.6. Тусгай зөвшөөрлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээ шинэчлэн байгуулах тохиолдолд Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчид цахим хуудас, эсхүл албан бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор хариу ирүүлээгүй тохиолдолд гэрээнд оруулах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

8.7. Тусгай зөвшөөрлийн гэрээг Монгол хэл дээр байгуулна.

ЕС. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС БОЛОН РАДИО ДАВТАМЖ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

9.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, радио давтамж ашиглалт, үйлчилгээний төлбөр /цаашид "тусгай зөвшөөрлийн төлбөр" гэх/-ийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны туршид Зохицуулах хорооны баталсан

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ” болон “Радио давтамжийн төлбөрийн хэмжээ”-нд заасны дагуу жил бүр тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан хугацаанд төлнө.

- 9.2. Зохицуулах хороо нь энэ журмын 9.1-д заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээнд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд цахим хуудсаар эсхүл бичгээр мэдэгдэх ба холбогдох шийдвэрийг өөрийн цахим хуудсанд байршуулна.
- 9.3. Төлбөрийн зөрчлийн улмаас түдгэлзүүлсэн хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөр тооцогдохгүй бөгөөд тусгай зөвшөөрлийг сэргээсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түдгэлзүүлсэн хугацааны тусгай зөвшөөрлийн төлбөрийг нөхөн төлнө.
- 9.4. Үндэсний радио давтамжийн төлөвлөлт, стратегийн дагуу Зохицуулах хорооны шийдвэрээр радио давтамжийн зурвасыг чөлөөлөх зохицуулалт хийж, тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгосон тохиолдолд үлдсэн хугацааны төлбөр тооцооноос холбогдох баримтыг үндэслэн чөлөөлж болно.
- 9.5. Энэхүү журмын 9.4-т зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болсон тусгай зөвшөөрлийн төлбөрийг буцааж олгохгүй.
- 9.6. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30, 42.4-р зүйл заалтыг үндэслэн тэмдэгтийн хураамж төлнө.
- 9.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох хууль, энэхүү журам, тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд “Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх журам”-д заасан холбогдох мэдээллийг Монгол банкны Зээлийн мэдээллийн санд нийлүүлнэ.

АРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

- 10.1. Зохицуулах хороо нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийн бүртгэлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, регистрийн дугаар, үүсгэн байгуулагч, эзэмшил, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, хаяг байршил, тусгай зөвшөөрлийн төрөл, үйл ажиллагаа, хамрах хүрээ, хүчинтэй хугацаа, гэрээний үүргийн хэрэгжилт болон бусад мэдээллээр бүрдүүлэн, мэдээллийн аюулгүй байдал, архивын дотоод журмын бүртгэлжүүлж ажиллана.
- 10.2. Дэлхийн худалдааны байгууллагаас гаргасан Зохицуулалтын суурь зарчмууд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар үүрэг хүлээсний дагуу Зохицуулах хороо нь дараах мэдээллийг өөрийн цахим хуудаст мэдээлж, тогтмол шинэчилнэ. Үүнд:
 - 10.2.1. Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нөхцөл, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, шийдвэрлэхэд шаардагдах хугацаа;

- 10.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэр, хаяг, хэрэглэгчээс гомдол, санал хүлээж авах суваг, мэдээлэл, тусгай зөвшөөрлийн хамрах хүрээ, тусгай зөвшөөрлийн хугацаа;
- 10.2.3. Тусгай зөвшөөрлийн зохицуулалттай холбоотой тус хорооны хуралдааны болон бусад шийдвэрүүд;
- 10.2.4. Тусгай зөвшөөрлийн төлбөр⁶ийн мэдээлэл;
- 10.2.5. Түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, дуусгавар болсонд тооцсон тусгай зөвшөөрлийн мэдээллийг шийдвэрийн хамт;
- 10.2.6. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээлэл
- 10.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, байршил, утасны дугаар, хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, гүйцэтгэх удирдлага, холбоо барих ажилтны талаарх мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ тухайгаа нэмэлт, өөрчлөлт орсноос хойш 10 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.
- 10.4. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааны тайлан ирүүлэх маягтыг Үндэсний Статистикийн хороо, Олон улсын цахилгаан холбооны байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагад үндэслэн боловсруулж, Зохицуулах хорооны даргын тушаалаар баталгаажуулах ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийг батлагдсан маягт, холбогдох аргачлалаар тухай бүр хангаж ажиллана.
- 10.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байгаа үйл ажиллагааны тайланг энэхүү журмын 10.4-т заасан маягтын дагуу үнэн зөв гаргах ба хагас жилд 1 удаа (гэрээнд заасан хугацаанд) санхүүгийн тайлангийн хамт Зохицуулах хорооны статистик тайлан ирүүлэх цахим системээр болон шаардлагатай тохиолдолд цаасаар Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 10.6. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн тайланд үндэслэн харилцаа холбооны салбарын гүйцэтгэлийн үзүүлэлтийг нэгтгэн, тайлан боловсруулж, өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

АРВАН НЭГ. БУСАД

- 11.1. Тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээний эх хувийг үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ, гэрчилгээг нөхөж олгох хүсэлтийг зарлуулсан тухай холбогдох баримтын хамт Зохицуулах хороонд ирүүлэх ба Зохицуулах хороо нь “Нөхөж олгов” тэмдэглэл хийх ба ингэхдээ тусгай дахин хэвлэсэний зардлыг тооцож, авч болно.
- 11.2. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон болон дуусгавар болсонд тооцсон тухай шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шуудангаар хүргүүлэх ба шуудангийн хаяг тодорхойгүй шалтгаанаар буцаж ирсэн тохиолдолд өөрийн цахим хуудсаар нэг удаа олон нийтэд мэдээлнэ.

⁶ Энэхүү журмын 9.1-д заасан

11.3. Зохицуулах хороо нь гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед харилцаа холбооны сүлжээний ачааллын байдалд үндэслэн сүлжээ, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах зорилгоор тусгай зөвшөөрөлтэй холбоотой түр зохицуулалт хийж болох ба тухайн зохицуулалтын шийдвэрийн үйлчлэх хугацаа нь гамшгийн нөхцөл байдал дуусахад дуусгавар болно.

11.4. Энэхүү журмыг зерчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.

----- 00 -----

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУЛЖЭЭ БАЙГУУЛАХ, ТҮННИЙ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
(ААЯАТ ЗХ-ийн 15.16.2) ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмын Хассралт 1

| Хязгаарлалт нээц ашиглах эсэх | | Хариулцаа холбооны үйлчилгээ, үйлчилгээний төрөл | | Бурдулз баримт бичиг | | |
|----------------------------------|--|--|--|---|-----------------------------|-----------------------------|
| Д/Д | | Радио дэвтам ж | Сүлжээ ний дугаар | Хугацаа (жилийнээр) | | |
| 1 | Мэдээлэл холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах | Тийм / Үгүй | Олонг нөхцөл Сүлжээний талаарх Мэдээлэл | Хугацаа (жилийнээр) Хоёр Одоо Сүүрийн Холбоо Холбоон Тусгай зөвшөөрөл хүснэгчин талаарх Мэдээлэл | Бурдулз баримт бичиг | |
| | Үргэлжлэл холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах | 1. Хүсэлт гаргач нь эрх бүхий байх 2. "Хариулцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах 3. Хүсэлт гаргач нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдуулсан байх | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 | |
| | Мэдээлэл холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах | Тийм / Үгүй | Үргэлжлэл холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах 3. Өөрөйн эзэмшилийн сүлжэээтэй байх 4. Хүсэлт гаргач нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдуулсан байх | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 |
| | Мэдээлэл холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах | Тийм / Үгүй | Үргэлжлэл холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах 3. Хүсэлт гаргач нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдуулсан байх | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 | Хугацаа (жилийнээр) 5 |

| | | | | | | | |
|---|---|------|------|---|---|---|--|
| | | | | | | | |
| 2 | Сансрын холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах | Тийм | Үгүй | 1. Хүсэлт гаргач нь эрх бүхий байх 2. Радио давтамжийн зуравас ашиглах тусгай зөвшөөрөл 3. "Мэдээлэл холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах" үйлчилгээг ижил нөхцөл хангах 4. Хүсэлт гаргач нь тухайн үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдулсан байх | 5 | 5 | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага |
| 3 | Шуудангийн сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргач нь эрх бүхий байх 2. "Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлагатай" баримт бичигт заасан нөхцөл, шаардлагыг хангах 3. Хүсэлт гаргач нь тухайн үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдулсан байх | 5 | 5 | 1. Шуудангийн сүлжээний төлөвлөлт (форматын дагуу) 2. Бизнес төлөвлөгөө (форматын дагуу) 3. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539-2019) 4. Техникийн узуулэлтүүд (MNS 5380-1:2004, MNS 5380-2:2004) 5. Гадаад харилцагчтай байгуулсан гэрээний хуулбар, гадаад харилцагчийн аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, татвар төлсөн баримт |
| | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|------------------------------|----------------------|----------------|---|------|------|---|--|--|
| | | | | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх 2. "Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шaaрдлагага" баримт бичигт заасан нөхцөл, шаардлагыг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боловжийг бурдуулээн байх | Үгүй | Үгүй | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтнуудын дипломын мэргэжлийн хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Шуудангийн сүлжээний төлөвлөлөт (форматын дагуу) 2. Бизнес төлөвлөлөөт (форматын дагуу) 3. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 4. Техникийн Узулэлтууд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) | |
| | | XOT XOOPOH A /GvCnH/ | XOTPIH AOTPOXn | 1. Улс хоорондын шуудангийн сүлжээний төв нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байх 2. "Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шaaрдлагага" баримт бичигт заасан нөхцөл, шаардлагыг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боловжийг бурдуулсан байх | Үгүй | Үгүй | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтнуудын дипломын мэргэжлийн хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Шуудангийн сүлжээний төлөвлөлөт (форматын дагуу) 2. Бизнес төлөвлөлөөт (форматын дагуу) 3. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 4. Техникийн Узулэлтууд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) | |
| 4 | Суурин холбоо | Тийм / Үгүй | Тийм | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх. 2. "Харилцаа холбосны Үйлчилгээ эрхлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах. 3. Хүсэлт гаргагч нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боловжийг бурдуулсан байх Сонгон шалгаруулалтаар (Хязгаарлагдмал нөөцийн зохицуулалт) олгох бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцлийг хангасан байх | | Тийм | Тийм | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн Узулэлтууд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) | Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан баримт бичиг |
| | Сансрын хөдөлгөөнт холбоо | Тийм | Тийм | 1. Хүсэлт гаргагч эрх бүхий байх 2. Радио давтамжийн зурvas | | | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн Узулэлтууд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) | 1. Бизнес төлөвлөлөөт (форматын дагуу) | |

| | | | | | | | |
|---|--|----------------|--|--|--|---|---|
| | | | | | | ажилтны мэргэжлийн дипломын хуулбар | 2. Сулжээ, Үйлчилгээний төлөвлөлт (форматын датуу) |
| | | | | | | 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| 5 | Интернетийн үйлчилгээ | Тийм / Үгүй | | | | 1. Санхүүгийн тайллан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн болон мэргэшлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага 4. Инженер техникийн ажилтнуудайтاي байгуулсан гэрээ | 1. Бизнес төлөвлөгөө (форматын датуу) 2. Сулжээ төлөвлөлт (форматын датуу) |
| | | | | | | | |
| 6 | Харилцаа холбсны сургалт, засвар үйлчилгээ | Үгүй | | | | 1. Инженер техникийн ажилтны мэргэжлийн болон мэргэшлийн дипломын хуулбар 2. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага 3. Инженер техникийн ажилтнуудайтай байгуулсан гэрээ | 1. Техник хэрэгслийн иж бурдлийн мэдээлэл |
| | | | | | | | |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|--------------------------|------|------------------------|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 7 | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх. 2. "Шуудангийн Үйлчилгээ эрхлэхэд тавидах нөхцөл шаардлагат" баримт бичигт заасан нөхцлийг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдгүйсэн байх | 5 | 5 | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төвлөгөө (Форматын дагуу) 2. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 3. Техникийн Узүүлэлтүүд (MNS 5380-1:2004, MNS 5380-2:2004) 4. Гадаад харилцагчтай байгуулсан гэрээний хуулбар, гадаад харилцагчийн аж ахуйн наажийн гэрчилгээний хуулбар, татвар төлөн баримт |
| 8 | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх 2. "Шуудангийн Үйлчилгээ эрхлэхэд тавидах нөхцөл шаардлагат" баримт бичигт заасан нөхцлийг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн Үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдгүйсэн байх | 5 | 5 | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төвлөгөө (Форматын дагуу) 2. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 3. Техникийн Узүүлэлтүүд (MNS 5380-1:2004, MNS 5380-2:2004) |
| ЛЛЫГДААНЫН НӨХЦЭЛ | | ҮНҮҮДНҮҮЛСЭН НӨХЦЭЛ | | | | | |

| | | | | | | | |
|----|------|------|--|---|---|--|---|
| | | | | | | | |
| 9 | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх 2. "Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нэхцэл шаардлага" Баримт бичигт заасан нэхцэлийг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдүүлсэн байх | 3 | 3 | 1. Санхүүгийн тайллан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төлөвлөгөө (Форматын дагуу) 2. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 3. Техникийн үзүүлэлтүүд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) |
| 10 | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх 2. "Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавигдах нэхцэл шаардлага" Баримт бичигт заасан нэхцэлийг хангах 3. Хүсэлт гаргагч нь тухайн үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурдүүлсэн байх | 5 | 5 | 1. Санхүүгийн тайллан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төлөвлөгөө (Форматын дагуу) 2. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 3. Техникийн үзүүлэлтүүд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) 4. Гадаад харилцагчтай байгуулсан гэрээний хуулбар, гадаад харилцагчийн аж ахуйн нэжийн гэрчилгээний хуулбар, татвар төлсөн баримт |
| | | | ҮНС ХООПОНГАРЫН МУҮДИЛЧИННИЙ НӨХЦӨЛНӨХЧИЙН СҮССҮҮННІН ҮНСҮҮЛЭЛТ | | | | |

| | | | | | |
|----|------|------|--|---|--|
| | | | | | |
| 11 | Үгүй | Үгүй | 1. Хүсэлт гаргагч нь эрх бүхий байх 2."Шуудангийн үйлчилгээ эрхлэхэд тавидах нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийг хангах 3.Хүсэлт гаргагч нь тухайн үйлчилгээг эрхлах санхүүгийн боломжийг бурдулсан байх | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн ажилтны мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төвлөвлөө (Форматын дагуу) 2. Технологи ажиллагааны мэдээлэл (MNS 5539:2019) 3. Техникийн узуулэлтүүд (MNS 5380- 1:2004, MNS 5380- 2:2004) |
| | | | | | |
| | | | | | |

Харилцаа холбооны салбарыг үйл ажиллагаагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийн журмын Хавсралт 2

**РАДИО ДАВТАМЖ, РАДИО ДАВТАМЖИЙН ЗУРВАС АШИГЛАХ (ААУАТЗТХ-ИЙН 15.16.1) ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ НӨХЦӨЛ,
ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

| Д/д | Харилцаа холбооны үйлчилгээ | Олгох нөхцөл | Хугацаа (жилийнээс) | Бүрдүүлэх баримт бичиг | | Радио төхөөрөмжийн баталгаажуулалтын холбоогий |
|-----|--|--------------|------------------------|--|--|---|
| | | | | Хэрхэн | Radio сүржээ байгуулалтын Мэдээлэл | |
| 1 | Үүрэн холбооны үйлчилгээ | Олгох нөхцөл | | <p>1. Хүссэлт гаргасан зураваст радио давтамжийн нөөцтэй байх</p> <p>2. Үүрэн холбооны үйлчилгээ "Үйлчилгээ эрхлэх нөхцөл хангасан байх</p> <p>3. Ашиглах радио давтамжийн зуравас дахь "Радио давтамжийн хувваарилалт, техникийн нөхцөл, шаардлагага" баримт бичигт заасан нөхцөлүүг хангасан байх</p> <p>4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагеэр баталгаажуулсан төхөөрөмж ашиглах</p> | <p>1. Радио давтамжийн зуравас ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга</p> <p>2. Сүлжээний холболтын буудуч зураг, схем</p> <p>3. Радио төхөөрөмжийн техникийн Узулэлт, хамрах хүрээний тооцооол (Маягтын дагуу)</p> <p>4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь</p> | <p>1. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч эсвэл нийтийн мэдээлэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дун, сертификат</p> |
| 2 | Интернетийн үйлчилгээ | | | <p>1. Хувваарилагдсан зураваст радио давтамжийн нөөцтэй байх</p> <p>2. "Интернетийн үйлчилгээ" эрхлэх нөхцөл хангасан байх</p> <p>3. Ашиглах радио давтамжийн зуравас дахь "Радио давтамжийн хувваарилалт, техникийн нөхцөл, шаардлагага" баримт бичигт заасан нөхцөлүүг хангасан байх</p> <p>4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагеэр баталгаажуулсан төхөөрөмж ашиглах</p> | <p>1. Радио давтамжийн зуравас ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга</p> <p>2. Сүлжээний холболтын буудуч зураг, схем</p> <p>3. Радио төхөөрөмжийн техникийн Узулэлт, хамрах хүрээний тооцооол (Маягтын дагуу)</p> <p>4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь</p> | <p>1. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч эсвэл нийтийн мэдээлэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дун, сертификат</p> |
| 3 | Сансрын холбооны сүлжээ байгуулах, зэмших, ашиглах | | | <p>1. Хувваарилагдсан зураваст радио давтамжийн нөөцтэй байх</p> <p>2. Ашиглах радио давтамжийн зуравас дахь</p> | <p>1. Радио давтамжийн зуравас ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга</p> | <p>1. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч эсвэл</p> |

| | | | | |
|---|---|---|--|---|
| | <p>"Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага" баримт бичигт заасан нөхчлийг хангасан байх</p> <p>3. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах</p> | <p>2. Хиймэл дагуулын оператор компанийн мэдээлэл</p> <p>3. Хиймэл дагуулаас газар, газраас хиймэл дагуул хүртэл хамрах хүрээний зураглал, ажиллагааны будувч зураг, схем</p> <p>4. Радио төхөөрөмжийн төхникийн тооцоолол (Маягтын дагуу)</p> <p>5. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь</p> | ниийлгүүлэгчийн мэдэгэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн, сертификат | |
| 4 | <p>Сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ</p> | <p>1. Ашиглах радио давтамжийн зуравас дахь "Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхчлийг хангасан байх.</p> <p>2. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах</p> | <p>1. Сансрын хөдөлгөөнт холбооны стаңц ашиглахаар төлвлөж буй шалтгаан, түүний танилцуулга</p> <p>2. Хиймэл дагуулын оператор компанийн мэдээлэл</p> <p>3. Хэрэглэгчийн терминалын мэдээлэл, ажиллагааны зарчим, техникийн чуулзэлт</p> <p>4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь</p> | <p>1. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, тийдээрлэгч зөвлэл нийлгүүлэгчийн мэдэгэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн, сертификат</p> |
| 5 | <p>Радио, телевизийн газрын супрессийн үйлчилгээ</p> | <p>1. Тухайн зураваст радио давтамжийн нөөцтэй байх</p> <p>2. "Радио, телевизийн газрын супрессийн үйлчилгээ" эрхтэх нөхцөл хангасан байх</p> <p>3. Ашиглах радио давтамжийн зуравас дахь "Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага" баримт бичигт заасан нөхчлийг хангасан байх</p> <p>4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах</p> | <p>1. Радио давтамжийн зуравас ашиглахаар төлвлөж буй шалтгаан, танилцуулга</p> <p>2. Сүлжээний холболтын будувч зураг, схем</p> <p>3. Радио төхөөрөмжийн төхникийн тооцоолол (Форматын дагуу)</p> <p>4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь</p> | <p>1. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, тийдээрлэгч зөвлэл нийлгүүлэгчийн мэдэгэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн, сертификат</p> |
| 6 | <p>Олон суваг дамжуулах үйлчилгээ</p> | <p>Хиймэл дагуулаар дамжуулах</p> | <p>1. Тухайн зураваст радио давтамжийн нөөцтэй байх</p> <p>2. "Олон суваг дамжуулах үйлчилгээ" эрхтэх нөхцөл хангасан байх</p> <p>3. Ашиглах радио давтамжийн зуравас дахь "Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага" баримт бичигт заасан</p> | <p>1. Радио давтамжийн зуравас ашиглахаар төлвлөж буй шалтгаан, танилцуулга,</p> <p>2. Хиймэл дагуулын оператор компанийн мэдээлэл</p> <p>3. Суржээний холболтын будувч зураг, схем</p> |

| | | | | |
|--|---|---|---|--|
| | | | | |
| нөхцөлийг хангасан байх 4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах | | 4. Радио төхөөрөмжийн техникийн Узүүлэлт, хамрах хүрээний тооцоолол (Маягтын дагуу) 5. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь | | |
| Бусад | 5 | 5 | 1. Радио давтамжийн зурvas ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга 2. Сулжээний холболтын будувч зураг, схем 3. Радио төхөөрөмжийн техникийн Узүүлэлт, хамрах хүрээний тооцоолол (Маягтын дагуу) 4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь | 1. Радио төхөөрөмжийн тохиরлын гэрчилгээ, Үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн мэдэгдэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн, сертификат |
| Арилжааны радио, телевиз (Хэт богино долгион) | 5 | 5 | 1. Тухайн зурваст радио давтамжийн нөөцтэй байх 2. "Арилжааны радио, телевизийн үйлчилгээ" эрхлэх нөхцөл хангасан байх 3. Ашиглах радио давтамжийн зурvas дахь "Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагат" баримт бичитт заасан нөхцөлийг хангасан байх 4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах | 1. Радио давтамжийн зурvas ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга 2. Сулжээний холболтын будувч зураг, схем 3. Радио төхөөрөмжийн техникийн Узүүлэлт, хамрах хүрээний тооцоолол (Маягтын дагуу) 4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь |
| Арилжааны радио, телевиз (Урт, дунд, богино долгион) | 5 | 5 | 1. Тухайн зурваст радио давтамжийн нөөцтэй байх 2. "Арилжааны радио, телевизийн үйлчилгээ" эрхлэх нөхцөл хангасан байх 3. Ашиглах радио давтамжийн зурvas дахь "Радио давтамжийн хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагат" баримт бичитт заасан нөхцөлийг хангасан байх 4. Тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулсан төхөөрөмж ашиглах | 1. Радио давтамжийн зурvas ашиглахаар төлөвлөж буй шалтгаан, танилцуулга 2. Сулжээний холболтын будувч зураг, схем 3. Радио төхөөрөмжийн техникийн Узүүлэлт, хамрах хүрээний тооцоолол (Маягтын дагуу) 4. Үйл ажиллагаа эхлэх хугацааны хуваарь, ажиллах цагийн хуваарь |

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамын Хассралт 3

КОНТЕНТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ (АУАТЗХ-ИЙН 15.16.3) ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ НӨХЦӨЛ, ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

| №/Д | Харилцаа холбооны үйлчилгээний төрөл | Хягаадал нөөц ашиглах эсэх | | Олгох нөхцөл | Хугацаа (жилийэр) | Бүрдүүлэх баримт бичиг | |
|-----|--------------------------------------|----------------------------|------------------|--|-------------------|--|---|
| | | Радио дэвтамж | Супжээний дугаар | | | | |
| 1 | Контентын үйлчилгээ эрхлэх | | | 1. Хүсэлт гаргач нь эрх бүхий байх 2. "Контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага" баримт бичигт заасан нөхцөлийн хангах 3. Хүсэлт гаргач нь тухайн үйлчилгээг эрхлэх санхүүгийн боломжийг бурудуулсан байх | Тийм / Үгүй | 1. Санхүүгийн тайллан 2. Инженер техникийн ажилтын мэргэжлийн дипломын хуулбар 3. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага | 1. Бизнес төлөвлөөв (форматын дагуу) 2. Контент, үйлчилгээний талаарх танилцуулга, төлбөрийн тухай мэдээлэл 3. Контентын үйлчилгээний төлбөрийн системийн бүтцийн тухай танилцуулга 4. "Content management system"-ийн дэлгэрэнгүй тайлбар, системийн зураг 5. Хэрэглэгчийн контентын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн гомдолыг шийдвэр журам, CRM системийн танилцуулга |

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (ӨН-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 6.1) ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
(ААУАТЗХ-ИЙН 15.16.5.6.7 ОЛГОХ НӨХЦӨЛ, ХУГАЦАА, БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журамын Хасвралт 4

| Д/А | Харилцаа холбооны үйлчилгээний төрөл | Хязгаарлалгамал нөөц ашиглах эсэх | Олгох нөхцөл | Хягдаа (жил/аэр) | Бүрдүүлэх баримт бичиг | |
|-----|--|-----------------------------------|--------------|---|------------------------|---|
| | | | | | Сүрье | Тусгай зөвшөөрөл хүснэгийн талаарх мэдээлэл |
| 1 | Радио, телевизийн газрын сүрьеэний үйлчилгээ | Тийм | Үгүй | Сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан нөхцлийг хангасан байх | 5 | 5 |
| 2 | Олон нийтийн радио, телевиз | Үгүй | Үгүй | 1. Хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаа нь Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нийцсэн, холбогдох тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад заасан нөхцлийг хангасан байх 2. Радио, телевизийн газрын сүрьеэний дамжих техникийн боломж хангасан байх | 5 | 5 |
| 3 | Арилжааны радио, телевиз | Тийм / Үгүй | Үгүй | Сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, | 5 | 5 |

| | | | | | | |
|---|--|------------|---|--|-------|--|
| | (Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түхайд хуулийн 15.16.6.б. | | шаардлагад заасан нэхцлийг хангасан байх | | | 7.4.5.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам) |
| 4 | Өргөн нэвтрүүлгийн радио, телевиз | Тийм /Үгүй | Үгүй | 1. Сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан нэхцлийг хангасан байх 2. Радио, телевизийн газрын сүлжээгээр дамжих техникийн боломж хангагдсан байх | 5 5 | Сонгон шалгарууллах зарчмаар олгох ба сонгон шалгаруулалтын баримт бичигт нарийвчлан заана. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам) |
| 5 | Төлбөртэй радио, телевиз | Үгүй | Үгүй | Тусгай зөвшөөрлийн нэхцөл, шаардлагад заасан нэхцлийг хангасан байх | 5 5 | 1. Санхүүгийн тайлан 2. Инженер техникийн болон зайлшгүй байх шаардлагатай ажилтын мэргэжлийн дипломын хүлээр 3. Инженер техникийн болон зайлшгүй байх шаардлагатай ажилтнуудын ажлын туршилтага 4. Бизнес төлөвлөгөө (форматын дагуу) |
| 6 | Олон суваг Дамжуулах Үйлчилгээ (Хиймэл давуулаар дамжуулах) Олон суваг Дамжуулах Үйлчилгээ (Бусад) | Тийм | Үгүй | Сонгон шалгаруулалтын баримт бичиг, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан нэхцлийг хангасан байх | 10 10 | Сонгон шалгарууллах зарчмаар олгох ба сонгон шалгаруулалтын баримт бичигт нарийвчлан заана. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам) |

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХД БҮРДҮЛЭХ
БАРИМТ БИЧИГ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

| №/Д | Нэмэлт, өөрчлөлт | Бүрдүүлэх баримт бичиг | Тавигдах шаардлага |
|-----|---|---|--|
| 1 | Үйлчилгээний хамрах хүрээ, нутаг дэвсгэрт нэмэлт, өөрчлөлт оруулах (Журмын 5.1.1) | 1. Нэмэлт, өөрчлөлт оруулах хүснэгт 2. Нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, тайлбар 3. Бизнес төлөвлөгөө (форматын дагуу) 4. Сулжээ, үйлчилгээний төлөвлөлт (форматын дагуу) | 1. Тусгай зөвшөөрлийн гэрээний үүрэг, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг билүүлж ажилласан байх 2. Тухайн эрхлэх үйлчилгээнд хамааралтай "Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага" баримт бичгийн тусгай зөвшөөрөл олгох нөхцөлийг хангасан байх 3. Үйлчилгээний хамрах хүрээ тэлэх нь хүснэгт иргүүлсэн газар нутаг дахь тухайн үйлчилгээний зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдалд сарег нөлөөлөл узүүлэх эсэх дүгнэлт хийдсэн байх |
| 2 | Эрхлэх үйлчилгээний төрөлд нэмэлт өөрчлөлт оруулах (Журмын 5.1.2) | 1. Нэмэлт, өөрчлөлт оруулах хүснэгт 2. Нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, тайлбар 3. Бизнес төлөвлөгөө (форматын дагуу) 4. Сулжээ, үйлчилгээний төлөвлөлт (форматын дагуу) | 1. Эрхлэх үйлчилгээний төрөл нь тухайн харилцаа холбооны үйлчилгээндээс хамааралтай 2. Тусгай зөвшөөрлийн гэрээний үүрэг, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг билүүлж ажилласан байх |
| 3 | Радио давтамж, радио давтамжийн зуравас өөрчлөх (Журмын 5.1.3) | 1. Нэмэлт, өөрчлөлт оруулах хүснэгт 2. Нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, тайлбар 3. Радио төхөөрөмжийн тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн мэдэгэл, итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүн, сертификат | 1. Хүснэгт гаргасан зураваст радио давтамжийн нөөцтэй байх 2. Үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтын хүснэгтэд нийцсэн байх 3. Ашиглагч радио тоног төхөөрөмжийг тус хороо эсвэл олон улсын баталгаажуулалтын итгэмжлэгдсэн байгууллагатай баталгаажуулсан байна. |
| 4 | Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр өөрчлөх 3 эзэмшигчийн нэр өөрчлөх (Журмын 5.1.4) | 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр өөрчлөх 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (шинэ) | Улсын бүртгэлийн байгууллагын шийдвэрт (улсын бүртгэлийн гэрчилгээ) үндэслэн өөрчлөлтийг хийнэ. |